



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 135

Мандалговь

Үндсэн хөрөнгө дуудлагаар худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.3, 6.4 дэх хэсгийн 6.4.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:


Нэг: Өлзийт сумын Есөн жилийн дунд сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 1988 онд ашиглалтанд орсон, нийт 13,183,607.36 (арван гурван сая нэг зуун наян гурван мянга зургаан зуун долоон төгрөг гучин зургаан) мөнгөний балансын үнэ, 7,781,990.51 (долоон сая долоон зуун наян нэгэн мянга есөн зуун ерэн төгрөг тавин нэгэн) мөнгөний хуримтлагдсан элэгдэл бүхий цагаан гал тогооны барилгыг суурин газрын хамт актлан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Хөрөнгө худалдах доод үнийн хязгаарыг 5,401,616.85 (таван сая дөрвөн зуун нэг мянга зургаан зуун арван зургаан төгрөг наян таван) мөнгөөр тогтоон нээлттэй дуудлага худалдааг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар (С.Ууганбаяр)-т үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Өлзийт сумын Есөн жилийн сургуулийн захирал /М.Болормаа/-д даалгасугай.

Дөрөв: Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0100331